

“СҮҮ” ХК-ИЙН ТУЗ-ИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2017 оны 08-р сарын 04 өдөр

№ 09

Улаанбаатар хот

НОГДОЛ АШИГ ХУВААРИЛАХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 6 дугаар бүлэг, 76 дугаар зүйлийн 76.1 дэх хэсэг, “Сүү” ХК-ийн дүрмийн 8 дугаар бүлгийн 8.13.16 дах хэсэг, 11 дүгээр бүлэг болон 2017 оны 08 сарын 04 өдөр хуралдсан “Сүү” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Сүү” ХК-ийн нийт хуримтлагдсан ашгаас 2016 онд нийт 3,440,000,000 /Гурван тэрбум дөрвөн зуун дөчин сая/ төгрөгийг нийт хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг болгон олгохыг зөвшөөрсүгэй.
2. “Сүү” ХК-ийн нэгж хувьцаа тус бүрд 10 /Арав/ төгрөгийн ногдол ашгийг мөнгөн хэлбэрээр олгож, ногдол ашгийг тараах, түүнтэй холбоотой ажлыг зохион байгуулах, холбогдох баримт бичигт компанийг төлөөлөн гарын үсэг зурах эрхийг Гүйцэтгэх захирал /Б.Гантулга/-д болон Санхүүгийн албаны дарга /В.Шинэцэцэг/-нд тус тус олгосугай.
3. Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг “Сүү” ХК-ийн 2017 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бүртгэлийн өдрөөр буюу 2017 оны 04 дүгээр сарын 05-ны өдрөөр тогтоосугай.
4. Ногдол ашгийг хувьцаа эзэмшигчдэд 2017 оны 09 сарын 04 өдрөөс эхлэн олгож, 2017 оны 12 сарын 31 өдрийн дотор тарааж дуусгасугай.
5. Энэхүү шийдвэрийг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулахыг Гүйцэтгэх захирал /Б.Гантулга/-д даалгасугай.

ТУЗ-ИЙН ДАРГА:



/Д.ГАНБААТАР/

“СҮҮ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2017 оны 08-р сарын 04 өдөр

№ 09

Улаанбаатар хот

Хурлын цаг: 10:00-10:30,

Хурлын байршил: “Сүү” ХК-ийн Хурлын танхим,

Хурлын дарга: Д.Ганбаатар,

Хуралд оролцсон гишүүд:

- 1. Д.Ганбаатар
- 2. Д.Цэрэнжигмэд
- 3. Д.Уянга-Лянхуа
- 4. Д.Жамъян
- 5. Г.Баяр
- 6. Ц.Соёл-Эрдэнэ
- 7. Ш.Даваалимбэ
- 8. Б.Гантулга

Хурлын ирц: 66,7%

Хуралд урилгаар оролцсон хүмүүс:

- Санхүүгийн албаны дарга В.Шинэцэцэг,

Хэлэлцэх асуудал:

1. “Сүү” ХК-ийн нийт хуримтлагдсан ашгаас 2016 онд ногдол ашиг хуваарилах тухай асуудал,

Хэлэлцсэн нь:

1. “Сүү” ХК-ийн нийт хуримтлагдсан ашгаас 2016 онд ногдол ашиг хуваарилах тухай асуудал,

Танилцуулсан нь:

Д.Ганбаатар: Та бүхний энэ өдрийн амар амгаланг айлтгая.

“Сүү” ХК-ийн 2017 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар “Сүү” ХК-ийн 2011 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн № 29215 тоот “Зээлийн гэрээ”-ний дагуу IFC, BIO, PROPARGO байгууллагуудаас авсан 6,000,000 /Зургаан сая/ ам.долларын зээлийг хугацаанаас нь өмнө 2017 онд багтаан төлж, барагдуулан зээлийн гэрээний үүргээс чөлөөлөгдсөн нөхцөлд, ТУЗ-өөс хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг тараах тухай шийдвэр гаргах асуудлыг нийт хувьцаа эзэмшигчид хэлэлцэж, дэмжсэн болохыг та бүхэн мэдэж байгаа.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд хэлэлцсэн ёсоор бид энэхүү IFC, BIO, PROPARGO байгууллагуудаас авсан 6,000,000 /Зургаан сая/ ам.долларын зээлийг бүрэн төлж барагдуулан, зээлийн гэрээний үүргээс чөлөөлөгдөөд байгаа болохыг та бүхэнд дуулгахад таатай байна.

Ийнхүү зээлийн гэрээний үүргээс чөлөөлөгдсөнтэй холбоотойгоор “Сүү” ХК-ийн 2017 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцсэний дагуу бид “Сүү” ХК-ийн нийт хуримтлагдсан ашгаас 2016 онд ногдол ашиг хуваарилах тухай асуудлыг хэлэлцэх гэж байна.

Гүйцэтгэх удирдлагын зүгээс нийт хуримтлагдсан ашгаас 3,440,000,000 /Гурван тэрбум дөрвөн зуун дөчин сая/ төгрөгийг 2016 оны тайлант жилд дараах журмын дагуу хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг болгон тараах саналыг гаргасан байгааг танилцуулъя. Үүнд:

1. “Сүү” ХК-ийн нэгж хувьцаа тус бүрд 10 /Арав/ төгрөгийн ногдол ашгийг мөнгөн хэлбэрээр олгох,
2. Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг “Сүү” ХК-ийн 2017 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бүртгэлийн өдрөөр буюу 2017 оны 04 дүгээр сарын 05-ны өдрөөр тогтоох,
3. Ногдол ашгийг хувьцаа эзэмшигчдэд 2017 оны 09 сарын 04 өдрөөс эхлэн олгож, 2017 оны 12 сарын 31 өдрийн дотор тарааж дуусгах,

Гишүүдэд холбогдох материалыг тараасан байгаа.

Тусгай тэмдэглэл:

Д.Ганбаатар: Гишүүдэд асуух асуулт байна уу?

Ц.Соёл-Эрдэнэ: Зах зээл дээр ам.долларын ханш өсөөд байгаа энэ үед энэхүү гадаад зээлийн өрийг төлж барагдуулан зээлийн гэрээний үүргээс гарсанд баяртай байна. Хэлэлцэж буй асуудлыг дэмжиж байна.

Д.Ганбаатар: Гишүүдэд өөр асуух асуулт байна уу?

Бүх гишүүд: Асуух асуулт байхгүй.

Д.Ганбаатар: Та бүхэн дээрх ногдол ашиг хуваарилах тухай асуудал болон Гүйцэтгэх захирлын гаргасан саналыг зөвшөөрч байгаа эсэх дээр санал асууя.

Бүх гишүүд: Зөвшөөрч байна.

Д.Ганбаатар: Хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг тараахтай холбоотой ажлыг зохион байгуулах, холбогдох баримт бичигт компанийг төлөөлөн гарын үсэг зурах эрхийг Гүйцэтгэх захирал /Б.Гантулга/-д болон Санхүүгийн албаны дарга /В.Шинэцэцэг/-нд тус тус олгох, ногдол ашиг хуваарилах шийдвэрийг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулахыг Гүйцэтгэх захирал /Б.Гантулга/-д даалгах тухай асуудлыг зөвшөөрч байна уу?

Бүх гишүүд: Зөвшөөрч байна.

Шийдвэр:


1. “Сүү” ХК-ийн нийт хуримтлагдсан ашгаас 2016 онд нийт 3,440,000,000 /Гурван тэрбум дөрвөн зуун дөчин сая/ төгрөгийг нийт хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг болгон олгохыг зөвшөөрөх,
2. “Сүү” ХК-ийн нэгж хувьцаа тус бүрд 10 /Арав/ төгрөгийн ногдол ашгийг мөнгөн хэлбэрээр олгож, ногдол ашгийг тараах, түүнтэй холбоотой ажлыг зохион байгуулах, холбогдох баримт бичигт компанийг төлөөлөн гарын үсэг зурах эрхийг Гүйцэтгэх захирал /Б.Гантулга/-д болон Санхүүгийн албаны дарга /В.Шинэцэцэг/-нд тус тус олгох,
3. Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг “Сүү” ХК-ийн 2017 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бүртгэлийн өдрөөр буюу 2017 оны 04 дүгээр сарын 05-ны өдрөөр тогтоох,
4. Ногдол ашгийг хувьцаа эзэмшигчдэд 2017 оны 09 сарын 04 өдрөөс эхлэн олгож, 2017 оны 12 сарын 31 өдрийн дотор тарааж дуусгах,
5. Ногдол ашиг хуваарилах шийдвэрийг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулахыг Гүйцэтгэх захирал /Б.Гантулга/-д даалгах тухай асуудлыг тус тус баталсан тухай шийдвэр:

№	ТУЗ-ийн гишүүдийн нэрс	Санал		
		Дэмжсэн	Дэмжээгүй	Түдгэлзсэн
1.	Д.Ганбаатар	Тийм	-	-
2.	Д.Цэрэнжигмэд	Тийм	-	-
3.	Д.Уянга-Лянхуа	Тийм	-	-
4.	Д.Жамъян	Тийм	-	-
5.	Ц.Соёл-Эрдэнэ	Тийм	-	-
6.	Г.Баяр	Тийм	-	-
7.	Ш.Даваалимбэ	Тийм	-	-
8.	Б.Гантулга	Тийм	-	-

Хянасан:

ТУЗ-ИЙН ДАРГА:

ТУЗ-ИЙН ГИШҮҮД:



..... / Д.ГАНБААТАР /
..... / Д.ЦЭРЭНЖИГМЭД /
..... / Д.УЯНГАЛЯНХУА /
..... / Д.ЖАМЪЯН /
..... / Ц.СОЁЛ-ЭРДЭНЭ /
..... / Б.ГАНТУЛГА /
..... / Г.БАЯР /
..... / Ш.ДАВААЛИМБЭ /

Тэмдэглэл хөтөлсөн:

Нарийн бичгийн дарга

Б.Цэрэндорж